



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**



**МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧНИЙ ДУТАГДАЛ,
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АЖЛЫН УЯЛДАА ХОЛБОО
ХАНГАЛТГҮЙ БАЙГАА НЬ ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХЭД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БАЙНА.**

2020 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Аудитын менежер Г.Наранбаяр Аудитор Б.Дарханбат М.Ундармаа 2020 оны 06 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70543151 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 дугаар давхар, 209 тоот	Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Бүлэг 1 Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байдал нь хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. 7 1.1. Байгууллага хуулиар болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажилласан байна. 7 1.1.1. Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, орон нутгийн онцлог, хууль эрх зүйн орчноос шалтгаалж тухайн ашигласан нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулах хөрөнгийг зориулалтын дагуу хуваарилах нөхцөл бүрдээгүй байна. 7 1.1.2 Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөв санхүү, хүний нөөц дутагдалтай байгаагаас үр дүнтэй хэрэгжих нөхцөл нь бүрдээгүй байна. 11 1.2 Мэргэжлийн боловсон хүчин, хүний нөөцөөр бүрэн хангагдаагүй байна. 13 1.2.1 Байгууллагын дүрэм, аймгийн Засаг даргаар батлагдсан ажил үүргийн хуваарийг шинээр хэрэгжиж буй Төрийн албаны тухай хууль, журам, заавартай нийцүүлэн шинэчлэн батлуулах шаардлагатай байна. 13 1.2.2 Мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдаагүй байна. 14 Бүлэг 2 Үйл ажиллагааны зардлыг бодитой төлөвлөсөн ба хөрөнгийн худалдан авалт, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт үр дүнтэй байна. 16 2.1 Үйл ажиллагааны зардлыг бодитой төлөвлөж арвилан хэмнэлттэй үр ашигтай зарцуулсан байна. 16 2.1.1 Байгууллагын урсгал үйл ажиллагааны зардлыг бодитой төлөвлөсөн байна. 16 2.1.2 Орлогыг бүрэн бүрдүүлж, үнэн зөв бүртгэж, тайлагнасан байна. 18 2.1.3 Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулсан байна. 18 2.2 Хөрөнгийг хууль журмын дагуу бэлтгэж, үнэн зөв бүртгэж тайлагнасан ба хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт үр нөлөөтэй байна. 20 2.2.1 Хөрөнгө, бараа материалын худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна. 20 2.2.2 Өмч, хөрөнгийг хууль журмын дагуу үнэн зөв бүртгэсэн байна. 22 Бүлэг 3 Дотоод хяналт үр дүнтэй эсэх 23 3.1 Дотоод хяналт үр дүнтэй хэрэгжээгүй байна. 23 3.1.1 Байгууллагын удирдлага хууль тогтоомжоор хүлээсэн хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна. 23
--	--

	3.1.2 Бусад байгууллагаас тус газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна. 24
	3.1.3 Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажилласан байна..... 24
	ДҮГНЭЛТ 25
	АУДИТЫН ЗӨВЛӨМЖ..... 25
	ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ: 25
	ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:..... 25

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 5 дугаар тогтоол, “Аудитын төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны 100 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлийн аудитыг хийлээ.

2. Аудитын зорилт:

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2018-2019 оны үйл ажиллагааны үр дүнд Гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитад сумдын ЗДТГ, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2018-2019 оны үйл ажиллагааг хамруулсан ба үйл ажиллагаатай холбоотой бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны тайлан, мэдээ, анхан шатны баримт материал, судалгаанд тулгуурлан аудитыг хийж гүйцэтгэсэн.

4. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг ашигласан бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, байгууллагын хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, аудитор Б.Дарханбат, М.Ундармаа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7. Хүндрэл бэрхшээл

Баянтал сумын ЗДТГ-ын дарга В.Гантуяа нь шаардсан баримт материалыг хугацаанд нь гаргаж ирүүлээгүй нь аудитад шаардлагатай нотлох баримтыг олж авах, тулган баталгаажуулах боломжгүй болгож аудитын үйл ажиллагаанд хүндрэл учрууллаа.

8. Үндсэн мэдээлэл

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь 2004 оноос өмнө Улсын байцаагчийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 67, 2015 оны 08 дугаар тогтоолоор Байгаль орчин аялал жуулчлалын газар нэртэйгээр 12 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна. Үйл ажиллагааны үндсэн чиглэл нь байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар явуулж байгаа төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна.

2018 онд 344,957,1 мянган төгрөгийн зардал төлөвлөснөөс гүйцэтгэлээр үйл ажиллагааны зардалд 307,455.9 мянган төгрөгийг зарцуулж, 37,501.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үүнээс 6,974.5 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардлаас 30,526.7 мянган төгрөгийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас тус тус хэмнэгджээ.

2019 онд 405,192.6 мянган төгрөгийн зардал төлөвлөснөөс гүйцэтгэлээр үйл ажиллагааны зардалд 347,448.9 мянган төгрөгийг зарцуулж, 57,743.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үүнээс 14,924.4 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардлаас 42,819.1 мянган төгрөгийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас тус тус хэмнэгджээ.

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас хийгдсэн санхүүгийн тайлангийн аудитаар 2018, 2019 онд зөрчилгүй дүгнэлт авсан ба аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг 2018 онд 95.2%, 2019 онд 94.%-тай үнэлүүлсэн байна.

Бүлэг 1

Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байдал нь хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

1.1. Байгууллага хуулиар болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажилласан байна.

1.1.1. Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, орон нутгийн онцлог, хууль эрх зүйн орчноос шалтгаалж тухайн ашигласан нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулах хөрөнгийг зориулалтын дагуу хуваарилах нөхцөл бүрдээгүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаас байгаль орчин, аялал жуулчлалын талаарх бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа орон нутагтай хамтарч ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулах зорилгоор аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллажээ.

Уг гэрээний хавсралтаар 2018 онд 30, 2019 онд 50 арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан бөгөөд гэрээний биелэлтийг 2018 онд 93.6%, 2019 онд 97.4%-ийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Гэрээний хүрээнд төлөвлөж хэрэгжүүлсэн арга хэмжээ нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон төрөөс баримталж буй бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн байна.

Аймгийн Засаг даргаас БОАЖГ-ын даргатай байгуулсан гэрээнд 2018 онд 6 зорилт 55 арга хэмжээ, 2019 онд 6 зорилт 57 арга хэмжээ төлөвлөж, аймгийн ХШҮДАХ-ээс 2018 онд 95.2%, 2019 онд 94%-тай дүгнэгджээ.

Байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл:

Хүснэгт 1

Он	Нийт төлөвлөсөн арга хэмжээ	Байгаль орчин		Аялал жуулчлал		Дотоод ажил бусад	
		Арга хэмжээний тоо	Эзлэх хувь	Арга хэмжээний тоо	Эзлэх хувь	Арга хэмжээний тоо	Эзлэх хувь
2018	55	36	65.5%	4	7.3%	15	27.2%
2019	57	36	63.2%	5	8.8%	16	28.0%

Хүснэгтээс харахад: Тус байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгдсөн арга хэмжээний 63.2-65.% нь байгаль орчин, 7.3-8.8% нь аялал жуулчлал, 27.2-28% нь дотоод ажлын чиглэлээр батлагдсан байна. Тус байгууллага нь байгаль орчны чиглэлд арга хэмжээгээ илүү төлөвлөж, аялал жуулчлалын чиглэлээр тусгасан арга хэмжээг “Аялал жуулчлалын дэд хөтөлбөр”-т тусган хэрэгжүүлж байна.

Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр 2018 онд 18, 2019 онд 12 арга хэмжээ батлагдсаныг тухайн жилийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 2

№	Бодлогын баримт бичиг	2018 он	2019 он
1	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	94.4%	94.7%
2	Аймгийн Эдийн Засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	94.4%	95.0%

Байгаль орчин, аялал жуулчлалын салбартай холбоотой аймгийн ИТХ, Засаг даргын шийдвэрийг хяналтад авч хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

№	Шийдвэрийн нэр	2018	Хүснэгт 3 2019
			2019
1	АИТХ-ын тогтоол	7	9
2	АЗД-ын захирамж	23	25

2011 онд АИТХ-аар батлагдсан “Ус” дэд хөтөлбөр, 2018 онд батлагдсан “Агаар орчны бохирдлыг бууруулах” дэд хөтөлбөрийг тус тус хяналтад авсан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, аймгийн Засаг даргаас төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээ болон аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцүүлэн ажлаа төлөвлөж хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн байна.

Харин байгаль орчны хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг анхан шатанд зохион байгуулах үүрэг бүхий сумдын ЗДТГ, байгаль орчны байцаагч нарын үйл ажиллагаатай танилцахад дараах байдалтай байна.

Сумдын ЗДТГ-ын 2018-2019 оны төлөвлөгөөнд байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр тусгасан арга хэмжээний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Он	Төлөвлөсөн арга хэмжээний тоо		Тайлагнасан арга хэмжээ гүйцэтгэлийн хувь	
	Байгаль орчин	Аялал жуулчлал	Байгаль орчин	Аялал жуулчлал
Сүмбэр				
2018	11	3	94%	100%
2019	10	1	100%	100%
Шивээговь				
2018	10	1	94%	1%
2019	10	1	90%	100%
Баянтал				
2018	0	0	0	0
2019	0	0	0	0

Хүснэгтээс харахад: Баянтал сумын ЗДТГ-ын 2018, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр хийгдэх арга хэмжээ огт тусгагдаагүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2018 оны 03 сарын 14-ний өдрийн 54 тоот албан бичгээр сумдын Засаг дарга нарт 2018 онд байгаль орчны салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, төрөөс баримталж буй бодлогын хүрээнд сумдтай хамтран ажиллах чиглэлийг хүргүүлсэн боловч, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхойгүй, үйл ажиллагааны төлөвлөгөөнд байгаль орчинтой холбоотой төлөвлөсөн ажил байхгүй, шаардсан мэдээ тайланг аудитад хамруулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.4, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Цаашид төрийн байгууллагын уялдаа холбоог сайжруулах, байгаль орчин, аялал жуулчлалын талаар аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцүүлэн ажлаа төлөвлөж, хэрэгжүүлэх албан шаардлагыг Баянтал сумын Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах явцад аймаг, сумын татварын орлогын дансанд төвлөрч буй байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос тухайн ашигласан нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хуульд заасны дагуу тооцож батлуулаагүй зөрчил илэрлээ.

Тухайлбал: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасны дагуу аймаг, сумын татварын орлогын дансанд байгалийн нөөц ашигласны төлбөр 2018 онд 433,820.9 мянга, 2019 онд 579,566.5 мянган төгрөг тус тус төвлөрсөн байна.

Татварын орлогыг төрлөөр нь харуулбал:

Татварын төрөл	Хүснэгт 5 /мянган төгрөгөөр/					
	Сүмбэр сум		Баянтал		Аймаг	
	2018	2019	2018	2019	2018	2019
Газрын төлбөр					170,927.17	223,453.79
Ан, амьтны нөөц ашигласны төлбөр	4,838.20	123,699.90	6,600.00	99,600.00	11,438.17	223,299.85
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр					251,455.55	132,812.94
Дүн	4,838.20	123,699.90	6,600.00	99,600.00	433,820.90	579,566.59

Хүснэгтээс харахад: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого нь газрын төлбөр болон ан амьтан, ус рашааны нөөцийг ашигласны төлбөрөөс бүрдэж байна.

Эдгээр орлогоос хууль, журмаар зохицуулсан хувь хэмжээгээр мөнгөн дүнг тооцож, дараа жилийн төсөвт байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөн, аймгийн ИТХ-ын тогтоолоор хэрэгжүүлэх арга хэмжээ, санхүүжилтийг баталдаг байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 10-р тогтоолын 2-р хавсралт, 2019 оны 9-р тогтоолын 2-р хавсралтаар БХНСАХЗ-г дараах байдлаар баталжээ.

№	БХНСАХЗ-аас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, нэр төрөл	Хүснэгт 6 Мянган төгрөгөөр			
		Аймгийн төсөвт төвлөрсөн БНАТ-ийн орлогоос тухайн нөөцийг нөхөн сэргээх зардлын доод хэмжээний дүн			
		2018 он	2019 он	2019 он	2020 он
1	Байгалийн ургамлын нөөцийг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ			8,364.16	5,098.53
2	Ус рашааны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	88,009.44	46,484.53	3,000.00	2,000.00
3	Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ			165,517.33	154,576.50
4	Ан, амьтны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ			34,076.66	8,373.53
5	Газрын нөөцийг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ	25,639.08	33,518.07	8,214.16	11,955.83
6	Бусад арга хэмжээ			2,499.00	16,095.60
Нийт		113,648.52	80,002.60	261,671.30	198,100.00

Хүснэгтээс харахад: Аймгийн татварын орлогын дансанд төвлөрсөн ус рашааны нөөц ашигласны төлбөрийн 2018 онд төвлөрсөн орлогоос 35%-иар тооцож 88,009.4 мянган төгрөгийг ус рашааны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар байсан боловч 3,000.0 мянган төгрөг, 2019 онд төвлөрсөн орлогоос 35%-иар тооцож 46,484.5 мянган төгрөгийг зарцуулахаар байсан боловч 2,000.0 мянга, газрын төлбөрийн 2018 онд төвлөрсөн орлогоос 15%-иар тооцож 25,639.0 мянган төгрөгийг газрын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулахаар байсан боловч 8,214.1 мянга, 2019 онд төвлөрсөн орлогоос 15%-иар тооцож 33,518.0 мянган төгрөгийг газрын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулахаар байсан боловч 11,955.8 мянган төгрөгийг тус тус зарцуулахаар баталсан нь ашигласан нөөцийг нөхөн сэргээхэд батлагдаж байгаа төсөв нь хуульд заасан доод хэмжээнд хүрэхгүй байгааг харуулж байна.

Дээрх нөхцөл байдал нь хуульд хэдийгээр хуульчлан зааж өгсөн боловч орон нутгийн онцлогоос шалтгаалан зарим нэр төрлийн орлогыг бүрдүүлэх боломжгүй, үүнтэй холбоотойгоор хэрэгжүүлэх арга хэмжээний эх үүсвэр дутагдалтайгаас төсөвт төвлөрсөн орлогын ангиллыг харгалзахгүйгээр төсвийг хуваарилан баталж байна. Тухайлбал:

1. Аймгийн төсөвт төвлөрч байгаа БНАТ нь зөвхөн ус рашаан болон газрын төлбөрийн орлогоос бүрддэг ба тус аймаг нь байгалийн бүтцийн хувьд дов толгод бүхий хээр талын бүсэд оршдог, цөлжилт нэмэгдэж байгаа тул ойн нөөцийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх нь орон нутагт нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээ болсон тул энэ чиглэлд төсвийг голчлон баталдаг.

2. Тухайн ашигласан нөөцийг нөхөн сэргээх зардлын доод хэмжээг уян хатан байдлаар тогтоогоогүй, орон нутгийн онцлогийг харгалзан нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнд зарцуулах хууль эрх зүйн орчин бүрдээгүйгээс шалтгаалсан байна.

Сумдын хувьд ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 2018 онд 11,438.1 мянга, 2019 онд 223,299.8 мянган төгрөг тус тус төвлөрсөн байна.

Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос тухайн ашигласан нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах доод хязгаар болон зарцуулахаар батлагдсан мөнгөн хөрөнгийг сум тус бүрээр хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7 мянган төгрөгөөр					
Сум	БХНСАХЗ-аас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ нэр төрөл	2018 оны төлбөрөөс хууль, журамд заасны дагуу БХНСАХ-д зарцуулах мөнгөн дүн	2019 оны төлбөрөөс хууль, журамд заасны дагуу БХНСАХ-д зарцуулах мөнгөн дүн	2019 оны ОНХС-д тусгагдсан тухайн ашигласан нөөцийг нөхөн сэргээхэд батлагдсан дүн	2020 оны ОНХС-д тусгагдсан тухайн ашигласан нөөцийг нөхөн сэргээхэд батлагдсан дүн
Сүмбэр	Ан амьтны нөөцийг хамгаалах,	2,419.1	61,850.0	-	1,000.0
Баянтал	нөхөн сэргээх арга хэмжээ	3,300.0	49,800.0	-	-
Нийт		5,719.10	111,649.95	0.00	1,000.00

Татварын орлогын дансанд 2018 онд төвлөрсөн ан, амьтны нөөц ашигласны орлогоос 50%-иар тооцож 5,719.1 мянга, 2019 онд 111,649.9 мянган төгрөгийг тухайн ашигласан нөөцийг нөхөн сэргээх, зүй зохистой ашиглахад зарцуулаагүй бөгөөд уг орлого сумдын тасарсан орлогын төлөвлөгөөг нөхөх байдлаар урсгал зардалд зарцуулагджээ.

Сумдын хувьд БНАТ-ийн орлогыг зориулалтын дагуу хуваарилж, зарцуулах бүрэн боломжтой боловч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахгүй байна. Үүнд сумдууд аймгийн хэмжээнд байгаль орчны талаар баримталж буй дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэн ажлаа төлөвлөж зохион байгуулдаггүй нь нөлөөлсөн байна.

Үүнээс үзэхэд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос тухайн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлын доод хязгаарыг баримталж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Цаашид байгалийн нөөц ашигласны төлбөрөөс тухайн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг хуульд заасны дагуу тооцож, сумын ИТХ-аар батлуулах, батлагдсан төсвийн хүрээнд аймгийн хэмжээнд байгаль орчны талаар баримталж буй дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэн ажлаа төлөвлөн ажиллах зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.1.2 Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөв санхүү, хүний нөөц дутагдалтай байгаагаас үр дүнтэй хэрэгжих нөхцөл нь бүрдээгүй байна.

Байгаль орчны газар нь салбарын хэмжээнд хэрэгжиж буй үндэсний хөтөлбөр болон орон нутагт батлагдсан дараах хөтөлбөрүүдийг хяналтад авч хэрэгжилтийг тайлагнаж ажилласан байна.

Хүснэгт 8

Үндэсний хэмжээнд хэрэгжиж буй хөтөлбөрүүдийг хүснэгтээр харуулбал:

№	Хөтөлбөрийн нэр	Хэрэгжих хугацаа	Биелэлтийн хувь		Санхүүжилтийн эх үүсвэр
			2018	2019	
1	Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	2016-2025		100	АОНХС, БХНСАХЗ
2	Монголын биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр	2016-2025	82.5	100	БХНСАХЗ
3	Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр	2014-2022	82.2	95	БХНСАХЗ
4	Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хөтөлбөр	2014-2040	73.3	86.6	АОНХС, Агаар орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр, хувийн хэвшил
5	Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр	1998-2015 оноос хойш	90	80	БХНСАХЗ
6	Цөлжилттэй тэмцэх тухай үндэсний хөтөлбөр	2010-2020	92.5	84.1	БХНСАХЗ
7	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр	2000-2015 оноос хойш	88.7	81.2	АОНХС, БХНСАХЗ
8	Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр	2005-2035	100	90	АОНХС, БХНСАХЗ, Гадны хөрөнгө оруулалт, ААНБ
9	Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	2017-2025	100	83.3	БХНСАХЗ
10	Ус үндэсний хөтөлбөр	2010-2021	100	75.5	БХНСАХЗ
11	Усны менежментийн нэгдсэн төлөвлөгөө	2014-2021		83.6	БХНСАХЗ
12	Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр	2018-2020		94	БХНСАХЗ
13	Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах өсгөн үржүүлэх үндэсний хөтөлбөр	2010-2021	92.5	85	БХНСАХЗ

Хүснэгтээс харахад: 13 үндэсний хөтөлбөрийн 9 буюу 69.2% нь зөвхөн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжсэн байна.

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд төсөв батлагддаггүй тул байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээтэй уялдуулан хэрэгжилтийг зохион байгуулжээ.

Биелэлтийг дунджаар авч үзвэл 2018 онд 90.1%, 2019 онд 87.5%-тай байгаа боловч хөтөлбөрийн хэрэгжилт өргөн хүрээг хамарч чаддаггүй, давхардсан байдлаар тайлагнагддаг, төсөв санхүү, хүний нөөцийн дутагдалтай байдал зэргээс шалтгаалан үр дүнтэй хэрэгжиж чадахгүй байна.

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв захирагчийн гэрээнд тусгагддаг боловч хэрэгжүүлэх эх үүсвэр нь тодорхой бус, төсөв нь орон нутагт батлагддаггүй үндэсний хөтөлбөрүүдийг бодлогын хэмжээнд цэгцлэх саналыг Үндэсний аудитын газарт уламжлахаар шийдвэрлэв.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 74-р тогтоолоор “Аялал жуулчлалыг хөгжүүлэх” дэд хөтөлбөр, 2018 оны 38-р тогтоолоор “Агаар орчны бохирдлыг бууруулах” дэд хөтөлбөрийг тус тус баталсан байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй дэд хөтөлбөрүүдийн төсөв гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 9

№	Хөтөлбөрийн нэр	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		мянган төгрөгөөр Хэмнэлт	
		2018	2019	2018	2019	2018	2019
1	Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр	23,000.00	28,000.00	22,994.10	25,900.37	5.90	2,099.63
2	Агаар орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр		10,000.00		993.52	-	9,006.48
Нийт дүн		23,000.00	38,000.00	22,994.10	26,893.89	5.90	11,106.11

Хүснэгтээс харахад: 2019 онд агаар орчны бохирдлыг бууруулахад баталсан 10,000.0 мянган төгрөгийн арга хэмжээнээс 993.5 мянган төгрөгийг зарцуулж, зардлын гүйцэтгэл 9.9%-тай байгаа нь уг хөтөлбөр тухайн жилийн зорилтот түвшиндээ хүрээгүйг харуулж байна. Батлагдсан төсөв нь хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээ уялдаж чадаагүй нь үүнд нөлөөлжээ. Тухайлбал:

1. Хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах зорилгоор “Жорлонгоо өөрчилъе” аяныг зохион байгуулахад 7,200.0 мянган төгрөг батлагдсан боловч энэ нь 9 айлын жорлонг шинэчлэхэд хүрэлцэхээр байгаа нь уг хөрөнгө бохирдлыг бууруулах хэмжээнд нөлөө үзүүлэхгүй буюу зарцуулалт үр ашиггүй болох тул тухайн арга хэмжээг өөр арга хэмжээнд зарцуулах болсонтой холбоотой байна.

Аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс “Агаар орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг 78.6%, аялал жуулчлалыг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг 94%-иар тус тус үнэлжээ.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт, санхүүжилтийг аймгийн ИТХ-ын 2017 оны 08, 2018 оны 10-р тогтоолоор тус тус баталсан байна.

Батлагдсан арга хэмжээ, санхүүжилтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 10

мянган төгрөгөөр

БХНСАХ-ний батлагдсан зориулалт	2018		2019		Хэмнэлт	
	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл	2018	2019
Хөрөнгө оруулалт	169,825.5	163,373.6	166,848.7	130,122.0	6,451.90	36,726.70
Хөтөлбөр, арга хэмжээ	47,724.5	28,367.0	94,822.6	88,730.0	19,357.55	6,092.56
Нийт дүн	217,550.0	191,740.6	261,671.3	218,852.0	25,809.45	42,819.26

Тайлбар: Өмнөх оноос он дамжин хэрэгжиж буй арга хэмжээний дүнг оруулаагүй.

Хүснэгтээс харахад: Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилтийн төсвийн гүйцэтгэл 2018 онд 191,740.6 мянган төгрөг буюу 88.1%, 2019 онд 83.6%-тай байна. Тухайлбал: 2018 онд нийт 25,809.5 мянган төгрөг хэмнэгдсэн бөгөөд үүний 18,000.0 мянга буюу 69.7%-ийг тарвага нутагшуулах, 4,850.0 мянга буюу 18.7% нь услалтын систем, хөв цөөрөм байгуулах ажлын зураг төсөв боловсруулах зардал, 2,959.5 мянга буюу 11.6%-ийг гэрээний хэмнэлт эзэлж байна.

2019 оны 42,819.3 мянган төгрөгийн хэмнэлтээс 10,000.0 мянга буюу 23.0% нь “Ногоон байгууламжийн ус нөөцлөх сав суурилуулах ажил”, 12,098.7 мянга буюу 28.0% нь “Ойн зурвас байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх /хамгаалалтын торон хашаа 5га/”, 3,733.0 мянга буюу 9% нь “БХНСАХ-ний хүрээнд хийгдэх хөрөнгө оруулалт, ТАХ-ний ажлын зураг төсөв, магадлал”, 40% буюу 16,987.6 мянган төгрөг нь гэрээний хэмнэлт байна.

БХНСАХ-ний зардлын хэмнэлтийн 60.0%-69.7% нь хэрэгжээгүй арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл байна.

Иймд хөрөнгө оруулалтын ажлын тоо хэмжээ, батлагдсан төсөв зэргийг харгалзан тендер зарлах, оролцогч ирээгүй тохиолдолд ХАА амжилтгүй болсон шалтгаан нөхцөлийг судлан дахин

зарлах зэргээр тухайн жилийн БХНСАХ болон ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зорилтот түвшин, гүйцэтгэлийг хангаж ажиллах шаардлагатай байна.

1.2 Мэргэжлийн боловсон хүчин, хүний нөөцөөр бүрэн хангагдаагүй байна.

1.2.1 Байгууллагын дүрэм, аймгийн Засаг даргаар батлагдсан ажил үүргийн хуваарийг шинээр хэрэгжиж буй Төрийн албаны тухай хууль, журам, заавартай нийцүүлэн шинэчлэн батлуулах шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Аймгийн засаг даргын тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” 9 дүгээр тогтоолын 4 дэх хэсэгт Байгаль орчин, аялал жуулчлалын газрыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэгч агентлаг гэсэн статустайгаар баталжээ.

Аймгийн Засаг даргын 2015 оны А/29 дүгээр захирамжаар Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дүрэм, ажил үүргийн хуваарь, орон тоог баталсан бөгөөд бүтцийг нь газрын дарга ажиллагсдыг шууд удирдлагаар хангах зарчмаар тодорхойлсон байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын батлагдсан 12 орон тоог албан тушаалаар нь хүснэгтээр харуулбал:

№	Албан тушаалын нэр	2019 орон тоо	Хүснэгт 11
			2018 орон тоо
1	Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга	1	1
2	Нягтлан бодогч	1	1
3	Дотоод ажил, тайлан мэдээ, хяналт шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн	1	1
4	Хүрээлэн буй орчны бохирдол, байгалийн гамшиг, Газрын асуудал хариуцсан мэргэжилтэн	1	1
5	Усны асуудал, байгаль орчин нөлөөлөх байдлын үнэлгээ, аудит хариуцсан мэргэжилтэн	1	1
6	Биологийн төрөл зүйл, ойжуулалт, байгаль орчны нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн	1	1
7	Аялал жуулчлалын асуудал, тусгай хамгаалалттай газар нутаг, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	1	1
8	Архив бичиг хэргийн эрхлэгч нярав	1	1
9	Сумдын байгаль хамгаалагч	2	2
10	Жолооч	1	1
11	Үйлчлэгч	1	1
Нийт дүн		12	12

Хүснэгтээс харахад: 2018, 2019 онд батлагдсан орон тоо, бүтцийн хувьд өөрчлөлт ороогүй боловч 10 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

Байгаль орчин аялал, жуулчлалын газрын даргын 2018 оны Б/01, 2019 оны Б/07-р тушаалаар аймгийн Засаг даргаас баталсан ажил, үүргийн хуваарийг өөрчилж баталжээ.

Энэ нь Төрийн албаны тухай хууль болон бусад дагалдан гарсан хууль тогтоомжийн шинэчлэлтэй холбоотой байна.

Иймд аймгийн Засаг даргын 2015 оны А/29 дүгээр захирамжаар батлагдсан байгууллагын дүрэм, ажил үүргийн хуваарь, бүтцийн схемийг шинээр хэрэгжиж буй Төрийн албаны тухай хууль болон дагалдан гарсан дүрэм, журамтай нийцүүлэх зөвлөмжийг аймгийн БОАЖГ-ын даргад өгөхөөр шийдвэрлэлээ.

1.2.2 Мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдаагүй байна.

Байгаль орчин аялал жуулчлалын газар нь 2018 онд 9, 2019 онд 10 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна. Тухайлбал: 2018 онд дотоод ажил, хяналт шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн-1, Ой ургамлын байгалийн ашиглалт, хамгаалалт, цөлжилт биологийн төрөл зүйл хариуцсан мэргэжилтэн-1, Агаар, хог хаягдал химийн хорт бодис байгалийн гамшгийн асуудал хариуцсан мэргэжилтэн-1, 2019 онд дотоод ажил, хяналт шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн-1, Усны нөөц ашиглалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтний орон тоо тус тус сул байсан бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2018 оны №136, 2019 оны №216 тоот албан бичгээр аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд сул ажлын байрны захиалга, ажлын байрны тодорхойлолтыг хүргүүлжээ.

Тус байгууллагын хүний нөөцийн талаарх мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийхэд дараах нөхцөл байдалтай байна. Үүнд:

1. Боловсон хүчний шилжилт хөдөлгөөнийг авч үзвэл:

Дүрслэл 1




2018 онд 7 ажилтан ажилд орж, 7 ажилтан ажлаас чөлөөлөгдөж, 1 ажилтан ажил хавсран гүйцэтгэсэн байна. 2019 онд 4 ажилтан шинээр томилогдож, 4 ажилтан ажлаас чөлөөлөгдөж, 2 ажилтан ажил хавсран гүйцэтгэж байна.

Үүнээс үзвэл ажиллагсдын орох гарах хөдөлгөөн их, ажилд орсон болон ажлаас гарсан хүмүүсийн тоо ижил, батлагдсан орон тоо байгаа боловч ажил хавсран гүйцэтгэж байгаа ажилтнуудын тоо өссөн зэрэг нь хүний нөөцөөр бүрэн хангагдаж чадаагүй, ажиллагсад тогтвор суурьшилтай ажиллахгүй байгааг харуулж байна.

2. Ажиллагсдын боловсролын түвшинг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 2



Дүрслэлээс харахад: Нийт ажилчдын 9 буюу 81.8% нь дээд, 2 буюу 22.2% нь бүрэн дунд боловсролтой байна.

3. Ажиллагсдын мэргэжлийг графикаар харуулбал:


Дүрслэл 3



Дүрслэлээс харахад: Нийт 11 албан хаагчдын 5 буюу 45% нь байгаль орчин, аялал жуулчлал, 4 буюу 36% нь төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах нягтлан бодогч, жолооч, үйлчлэгч, бичиг хэрэг зэрэг үйлчилгээний ажилтнууд, 2 буюу 18.1% нь эрх зүйч, төрийн захиргааны менежмент чиглэлээр мэргэжил эзэмшсэн байна.

4. Ажиллагсдыг тухайн байгууллагад ажилласан жилээр нь авч үзвэл:

Дүрслэл 4



Дүрслэлээс харахад: Нийт ажиллагсдын дийлэнх буюу 55% нь тус байгууллагад 1-2 ажиллаж байна.

Тус байгууллагын ажиллагсдаас удирдлагын үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалт, ажиллах нөхцөлийн талаар санал асуулга авсан бөгөөд үр дүн нэгтгэн харуулбал:

Санал асуулгад тус байгууллагад ажилладаг 25-45 насны 8 ажилтан буюу 72.8% нь хамрагдсан байна.

1. **Байгууллагын удирдлагын үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байдаг уу?** гэсэн асуултад санал асуулгад оролцсон 7 ажилтан 100% тийм гэж хариулсан байна.

2. **Ажиллагсдын нийгмийн баталгааг хэрхэн хангаж байна вэ?** гэсэн асуултад санал асуулгад оролцсон 8 ажилтны 5 буюу 62.5% нь дунд, 3 буюу 37.5% нь сайн гэж хариулсан байна.

3. **Ажилчдын зүгээс гаргасан санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэдэг үү?** гэсэн асуултад санал асуулгад оролцсон 8 ажилтны 7 буюу 87.5% сэтгэл хангалуун, 1 буюу 12.5% нь хариулаагүй байна.

4. **Та эрхэлж буй ажил албан тушаалдаа сэтгэл хангалуун байж чаддаг уу?** гэсэн асуултад санал асуулгад оролцсон 8 ажилтны 8 буюу 100% тийм гэж хариулсан байна.

5. **Ажиллагсдын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ, ажил дүгнэхдээ үнэн зөв шударгаар дүгнэдэг үү?** гэсэн асуултад санал асуулгад оролцсон 8 ажилтны 8 буюу 100% тийм гэж хариулсан байна.

6. **Ажиллагсдад төсөв санхүүгийн үйл ажиллагааны талаар тайлагнаж, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажилладаг уу?** гэсэн асуултад санал асуулгад оролцсон 8 ажилтны 7 буюу 87.5% нь тийм, 1 буюу 12.5% нь санхүүгийн үйл ажиллагааг хангалттай тайлагнадаггүй гэж хариулсан байна.

7. **Ажиллах орчин нөхцөл, техник хэрэгсэл болон тоног төхөөрөмж, бусад хангамж хангалттай байна уу?** гэсэн асуултад санал асуулгад оролцсон 8 ажилтны 6 буюу 75% нь тийм, 2 буюу 25% үгүй гэж хариулсан бөгөөд тавилга эд хогшлыг шинэчлэх болон байрны асуудлыг шийдвэрлэх талаар хүсэлт уламжилсан байна.

8. Цаашид байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой таны санал гэсэн асуултад дараах саналууд гарсан байна.

- Мэргэжлийн боловсон хүчнээр хангах, тогтвортой ажиллуулах
- Байр орон сууцны асуудлыг шийдвэрлэх
- Ил тод, нээлттэй байдлыг сайжруулах
- Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах гэжээ.

Санал асуулгын дүнгээс үзвэл удирдлагын үйл ажиллагаанд ажилтнууд сэтгэл ханамжтай байдаг боловч ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар тодорхой үр дүнтэй арга хэмжээ авах, ажиллагсдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэжлийн боловсон хүчнээр хангах асуудлууд тулгамдсан асуудал болсон байна.

Мөн ажиллагсдын цалин хөлсийг хууль журамд заасны дагуу тогтоосон эсэхийг шалгахад тус байгууллагын ахлах нягтлан бодогчийг тооцооны нягтлан бодогчийн зэрэглэлээр цалинжуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолын 3-р хавсралтын батлагдсан “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл”-ийн 5 дахь хэсэг, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд НББ-ийн тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд тус байгууллагын нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж байгаагийн хувьд ТҮ-8 зэрэглэлд хамаарах тул цалин хөлсний ангиллыг үнэн зөв тогтоох зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аудитаар тус байгууллагын ажиллагсдын хувийн хэргийн иж бүрдлийг шалгахад: 12 хувийн хэрэг нээхээс 11 ажилтанд хувийн хэрэг нээсэн боловч журмын дагуу баримт бичгийн бүрдүүлэлтийн шаардлага хангасан хувийн хэрэг байхгүй байна.

Иймд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг мөрдөж ажиллах, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Үйл ажиллагааны орлого, зарлагыг бодитой төлөвлөн, үр ашигтай зарцуулж, өмч хөрөнгийн худалдан авалт, хадгалалт хамгаалалт үр дүнтэй байна уу?

Бүлэг 2

Үйл ажиллагааны зардлыг бодитой төлөвлөсөн ба хөрөнгийн худалдан авалт, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт үр дүнтэй байна.

2.1 Үйл ажиллагааны зардлыг бодитой төлөвлөж арвилан хэмнэлттэй үр ашигтай зарцуулсан байна.

2.1.1 Байгууллагын урсгал үйл ажиллагааны зардлыг бодитой төлөвлөсөн байна.

Аймгийн БОАЖГ нь байгууллагын үйл ажиллагааны болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төсвийн төслийг төсөв боловсруулах удирдамжийн дагуу боловсруулж 2018 онд 332,579.2 мянга, 2019 онд 430,043.4 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн байна.



Тус байгууллагын төсвийн төсөл, батлагдсан төсвийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 12

/мянган төгрөгөөр/

Д.д	Арга хэмжээ	2018 он			2019 он		
		Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Зөрүү	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Зөрүү
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	114,741.2	111,768.7	(2,972.5)	124,943.4	140,221.3	15,277.9
2	Мэдээлэл сурталчилгааны зардал	300.0	300.0	-	300.0	300.0	-
3	Биеийн тамир уралдаан, тэмцээн	500.0	-	(500.0)	400.0	-	(400.0)
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж	800.0	4,200.0	3,400.0	4,400.0	3,000.0	(1,400.0)
5	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал	216,238.0	217,550.0	1,312.0	300,000.0	261,671.3	(38,328.7)
	Нийт дүн	332,579.2	333,818.7	1,239.5	430,043.4	405,192.6	(24,850.8)

Хүснэгтээс харахад: Аймгийн ИТХ-аас тус газрын төсвийг батлахдаа төсвийн төслийг 2018 онд 1,239.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2019 онд 24,850.8 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна. Тухайлбал:

- Үндсэн үйл ажиллагааны зардлыг 2018 онд өмнөх оны гүйцэтгэлийг үндэслэн 2,972.5 мянган төгрөгөөр бууруулсан бол 2019 онд Засгийн газрын тогтоолоор цалин сан нэмэгдүүлэхтэй холбоотойгоор 15,277.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн,
- Мэдээлэл сурталчилгааны зардлыг төлөвлөсөн хэмжээгээр баталсан бол биеийн тамир, уралдаан тэмцээний зардлыг хассан,
- Ажил олгогчоос олгох тэтгэмжийг 2018 онд төрийн албан хаагчдад олгох урамшуулалтай холбоотойгоор 3,400.0 мянган төгрөгөөр илүү, 2019 онд 1,400.0 мянган төгрөгөөр тус тус дутуу,
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.1-т заасны дагуу Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын 35%-иар байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг тогтоосон байна. 2018 онд төсвийн төслөөс 1,312.0 мянган төгрөгөөр илүү, 2019 онд 38,328.7 мянган төгрөгөөр дутуу баталсан байна.


2018 онд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын батлагдсан төсөвт тодотгол хийгдэж, 11,138.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2018 оны 03 дугаар тогтоолоор 344,957.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Харин 2019 онд АИТХ-ын 2018 оны 10 дугаар тогтоолоор 405,192.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд төсвийн тодотгол хийгдээгүй байна.

АИТХ-ын 2019 оны 04 дүгээр тогтоолоор байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөөнд 2018 оны шилжих үлдэгдлээс санхүүжүүлэх ажлын жагсаалтыг баталж өөрчлөлт оруулсан байна.

2018, 2019 онд батлагдсан төсвийг арга хэмжээ тус бүрээр нь харьцуулан харуулбал:

Дүрслэл 5



Дүрслэлээс харахад: Үндсэн үйл ажиллагааны зардлыг өмнөх оноос 25.4% буюу 28,452.6 мянга, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 14.4% буюу 32,982.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

Энэ нь 2019 онд төрийн албан хаагчийн цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор нэмэгдсэн байна.

Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардлыг өмнөх оноос 28.6% буюу 1,200.0 мянган төгрөгөөр бууруулж баталсан нь төрийн албан хаагчид олгох 300.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олголттой холбоотой байна. Мэдээлэл сурталчилгааны зардалд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын төсвийн төслийг бэлтгэхдээ үндсэн болон нэмэгдэл цалин, харилцагч байгууллагын үнэ тарифын өсөлт, байгууллагын хэрэгцээ шаардлага зэргийг судлан өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулан бодитой төлөвлөж, төлөвлөлтийг тайлбар тооцооллын хамт аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлж ажилласан байна.

2.1.2 Орлогыг бүрэн бүрдүүлж, үнэн зөв бүртгэж, тайлагнасан байна.

2018-2019 онд аймгийн БОАЖГ-т орлогын төлөвлөгөө батлагдаагүй боловч 2 төрлийн орлогыг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэж тайлагнасан байна. Туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн усны дүгнэлтийн болон нөхөн төлбөрийн орлогуудыг төлөвлөх боломжгүй бөгөөд нийт 7,037.5 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

Тухайлбал: 2018 онд усны дүгнэлтийн 1,080.0 мянга, нөхөн төлбөрийн 520.0 мянга, нийт 1,600.0 мянга, 2019 онд усны дүгнэлтийн 250.0 мянга, нөхөн төлбөрийн 5,187.5 мянга нийт 5,437.5 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Дүрслэл 6

Дүрслэлээс харахад: 2019 онд усны төлбөрийн орлого өмнөх оноос 830.0 мянган төгрөгөөр буурч, нөхөн төлбөрийн орлого 4,667.5 мянган төгрөгөөр өссөн байна. Усны дүгнэлтийн орлого буурсан нь БОАЖ-ын сайдын 2018 оны А/376 дугаартай тушаалаар ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг 360.0 мянгаас 50.0 мянга болгож өөрчлөлт оруулсантай холбоотой байна.



Харин нөхөн төлбөрийн орлого нь тухайн жилд өмнөх оноос хулгайн ан агнуурын илрүүлэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор өссөн байна.

Байгаль орчны үнэлгээ, усны асуудал хариуцсан мэргэжилтэн нь усны дүгнэлт гаргуулсан ААНБ-ын нэгдсэн бүртгэл хөтлөөгүй байна.

Иймд усны дүгнэлт гаргуулж байгаа байгууллага аж ахуйн нэгжүүдийн нэгдсэн бүртгэлийг хөтөлж, төлбөр төлөгдсөн байдалд хяналт тавьж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.1.3 Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулсан байна.

Дүрслэл 7

Аймгийн БОАЖГ нь батлагдсан төсвийн дагуу 2018 онд 344,957.1 мянга, 2019 онд 405,192.6 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч зарцуулсан бөгөөд батлагдсан төсвийн гүйцэтгэл 2018 онд 89.1 хувь, 2019 онд 85.7 хувь байсан ба төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын батлагдсан төсвийн үлдэгдэл 2018 онд 24,779.3 мянга,



2019 онд 42,333.0 мянга, нийт 67,112.3 мянган төгрөгийн бодит хэмнэлт тендер шалгаруулалттай холбоотойгоор үүссэн байна. Энэ нь төлөвлөлт бодитой хийгдээгүйг харуулж байна.

Тус газрын 2018-2019 оны төсвийн зарцуулалтыг зардлын зүйл ангиар нь хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 13

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2018			2019		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт
1	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	89,125.9	83,747.6	5,378.3	104,345.8	95,776.9	8,568.9
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,503.2	9,736.0	767.2	13,283.8	11,375.0	1,908.8
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,934.8	4,667.6	267.2	7,380.6	5,202.6	2,178.0
4	Хангамж, бараа материалын зардал	3,981.1	3,906.9	74.2	5,899.8	5,627.4	272.4
5	Нормативт зардал	45.5	44.0	1.5	60.0	-	60.0
6	Эд хогшил, урсгал засварын зардал	4,400.0	4,335.5	64.5	5,000.0	5,000.0	-
7	Томилолт, зочны зардал	1,533.0	1,118.5	414.5	2,605.9	2,558.5	47.4
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	977.2	970.0	7.2	1,288.4	1,160.4	128.0
9	Хичээл үйлдвэрлэл	168.0	168.0	-	657.0	510.0	147.0
10	Бараа үйлчилгээний бусад зардал/ БХНСАХ/	228,688.4	198,161.7	30,526.7	261,671.3	218,852.1	42,819.2
11	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	600.0	600.0	-	3,000.0	1,386.0	1,614.0
Дүн		344,957.1	307,455.9	37,501.2	405,192.6	347,448.9	57,743.7

Хүснэгтээс харахад: 2018 онд нийт 307,455.9 мянган төгрөгийг зарцуулж, нийт 37,501.2 мянган төгрөгийг хэмнэж, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Тухайлбал: Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 30,526.7 мянга, үйл ажиллагааны зардлаас 6,974.5 мянган төгрөг хэмнэгдсэн ба цалин хөлс болон нэмэгдэл урамшууллаас 5,378.3 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлээс 767.2 мянга, байр ашиглалттай тогтмол зардлаас 267.2 мянга, хангамж, бараа материалын зардлаас 74.2 мянга, норматив зардлаас 1.5 мянга, эд хогшил худалдан авах зардлаас 64.5 мянга, дотоод албан томилолтын зардлаас 414.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжаас 7.2 мянган төгрөг тус тус хэмнэгдсэн байна.

2019 онд Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 42,819.2 мянга, үйл ажиллагааны зардлаас 14,924.4 мянган төгрөг хэмнэж нийт 57,743.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Тухайлбал: цалин хөлс болон нэмэгдэл урамшууллаас 8,568.9 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлээс 1,908.8 мянга, байр ашиглалттай тогтмол зардлаас 2,178.0 мянга, хангамж, бараа материалын зардлаас 272.4 мянга, норматив зардлаас 60.0 мянга, томилолт зочны зардлаас 47.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 128.0 мянга, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 147.0 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгээс 1,614.0 мянган төгрөг тус тус хэмнэжээ.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 2018-2019 оны зарцуулалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 14

мянган төгрөгөөр

Д/д	Үзүүлэлт	2018			2019		
		Хөрөнгө оруулалт	Хөтөлбөр төсөл арга хэмжээ	Дүн	Хөрөнгө оруулалт	Тоног төхөөрөмж	Хөтөлбөр төсөл арга хэмжээ
1	Батлагдсан төсөв	171,825.5	56,862.9	228,688.4	96,864.7	57,000.0	107,806.6
							261,671.3

2	Гэрээний дүн	171,121.0	38,862.9	209,983.9	74,440.8	56,800.0	107,622.0	238,862.8
3	Олгосон санхүүжилт	165,273.6	32,888.0	198,161.7	73,954.5	56,167.5	88,730.0	218,852.1
4	Хяналтын зардал	5,747.4	-	5,747.4	486.3	-		486.3
	Дараа онд шилжих ажил болон батлагдсан төсвийн үлдэгдэл	804.5	23,974.9	24,779.3	22,423.9	832.5	19,076.6	42,333.0

Хүснэгтээс харахад: 2018 онд 228,688.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий хөрөнгө оруулалтын 7, хөтөлбөр төсөл арга хэмжээний 7, өмнөх оны үлдэгдлээс санхүүжих 2 ажлыг тус тус төлөвлөн нийт 16 ажилд 209,983.9 мянган төгрөгийн гэрээ байгуулж, 198,161.7 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, 24,779.3 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

2019 онд 261,671.3 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын 6, тоног төхөөрөмжийн 2, хөтөлбөр төсөл арга хэмжээний 11 ажлыг тус тус төлөвлөж, нийт 17 ажилд 238,862.8 мянган төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 218,852.1 төгрөгийн санхүүжилтийг олгож 42,333.0 мянган төгрөгийг хэмнэжээ.

2.1.4. Авлагыг бүртгэж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

2018-2019 онд аймгийн БОАЖГ нь өглөгийн үлдэгдэлгүй тайлагнасан боловч аймгийн Холбооны газраас 2018 онд 4.8 мянга, 2019 онд 8.0 мянган төгрөгийн авлагыг тус тус үүсгэж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.



2.2 Хөрөнгийг хууль журмын дагуу бэлтгэж, үнэн зөв бүртгэж тайлагнасан ба хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт үр нөлөөтэй байна.

2.2.1 Хөрөнгө, бараа материалын худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна.


2018-2019 онд БОАЖГ-т 6,957.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, мянган төгрөгийн 109,983.98 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт хийгдсэн байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудын худалдан авах ажиллагааг аймгийн ОНӨГ-аас холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна.

Үндсэн үйл ажиллагааны зардлаас 2018 онд 2 компьютер 2,528.0 мянга, 1 принтер 420.0 мянга, цаг бүртгэгч 539.0 мянга, 2019 онд 1 компьютер 2,562.0 мянга, 1 принтер 638.0 мянга, архивын программ 270.0 мянга, нийт 6,957.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хууль журмын дагуу бэлтгэж, анхан шатны баримтыг үдэж архивласан байна.

Үндсэн үйл ажиллагааны зардлаас болон байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2018 онд бичиг хэргийн материал 455.3 мянга, аж ахуйн материал 678.6 мянга сэлбэг хэрэгсэл 525.0 мянга, түлш шатахуун 6,009.9 мянга, бусад материал 63,803.2 мянга, нийт 71,472.1 мянга, 2019 онд бичиг хэргийн материал 8,842.2 мянга, аж ахуйн материал 1,361.1 мянга, сэлбэг хэрэгсэл 2,538.8 мянга, шатахуун 6,879.7 мянга, бусад хангамжийн материал 18,890.0 мянга, нийт 38,511.9 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус бэлтгэж тайлагнасан байна.

Дүрслэлээс харахад хөрөнгө, бараа материалын худалдан авалт өмнөх оноос 32,977.0 мянган төгрөгөөр буюу 43.9 хувиар буурсан байх ба худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна.



Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хийгдсэн дараах хөрөнгө оруулалтын ажлуудад худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Дүрслэл 9

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ-2018



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ-2019



2018 онд батлагдсан 171,825.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын 8 ажилд хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 171,121.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан байна. Тарвага нутагшуулах 18,000.0 мянган төгрөгийн ажлыг цаг уурын байдалтай холбоотойгоор дараа онд хэрэгжүүлэхээр шилжүүлсэн байна.

2019 онд 153,864.7 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 9 хөрөнгө оруулалтын ажил батлагдсанаас хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 7 ажилд 131,240.8 мянган төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, тендер шалгаруулалт амжилтгүй болсонтой холбоотойгоор 22,098.7 мянган төгрөгийн 2 ажил дараа онд шилжсэн байна.

2018-2019 онд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгө оруулалтын ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна.

2.2.2 Өмч, хөрөнгийг хууль журмын дагуу үнэн зөв бүртгэсэн байна.



Аймгийн БОАЖГ-т 2018-2019 онд үндсэн хөрөнгө 91,739.5 мянган төгрөгөөр буурсан бол бараа материал 20,937.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд:

2018 онд үндсэн үйл ажиллагааны зардлаас үнийн харьцуулалт хийж өмч хамгаалах байнгын зөвлөлтийн шийдвэрээр 3,487.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч тоног төхөөрөмжийн дансанд бүртгэсэн байна.

Мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын 2018 оны 273 дугаар тогтоолоор олгосон эрхийн дагуу БОАЖГ-ын А/20 тушаалаар бусад биет бус үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 15,700.0 мянган төгрөгийн Байгаль орчны газрын конторын барилгын зургийг дуусаагүй барилга дансанд, бараа материалын данснаас 1,881.3 мянган төгрөгийн хөрөнгийг тоног төхөөрөмжийн дансанд, 165.0 мянган төгрөгийн хөрөнгийг тавилга хэрэгслийн дансанд тус тус шилжүүлэн бүртгэсэн байна.

АИТХТ-ийн 2018 оны 50 дугаар тогтоолоор биет бус хөрөнгөд бүртгэлтэй байгаа 20,000.0 мянган төгрөгийн "Соёл амралтын хүрээлэн"-гийн зураг, төсвийг холбогдох газарт нь шилжүүлсэн байна.

Үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэхтэй холбогдуулан байгууллагын эзэмшилд буй 2 газрыг 319,200.0 мянган төгрөгөөр үнэлэн бусад биет бус үндсэн хөрөнгийн дансанд бүртгэжээ.

2019 онд 3,470.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, тоног төхөөрөмж, программ хангамжийн дансанд бүртгэсэн байна.


Үнэ төлбөргүй хүлээн авсан нийт 5,525.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнийг данс бүртгэлд бүрэн тусгасан байна. Үүнд: БОАЖЯ-наас 1 мотоцикл 1,860.0 мянга, аймгийн ГХУСАЗСЗ-өөс камер 250.0 мянга, НҮБ-ийн хөтөлбөрөөс дроны зурган мэдээлэл боловсруулах программын лиценз 3,415.1 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус бүртгэсэн байна.

АИТХТ-ийн 2019.12.13-ны өдрийн 49 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар 18 нэр төрлийн 13,233.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 878.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материал дансанд шилжүүлж, мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар Сумдын ойн ангид 86,623.3 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.

Биет бус хөрөнгийн данс тайлант онд 3,685.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 270.0 мянган архивын программ худалдан авсан, НҮБ-ийн хөтөлбөрөөс дроны зурган мэдээлэл боловсруулах программын 3,415.1 мянган төгрөгийн лицензийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

БОАЖГ-ын 2018-2019 оны үндсэн хөрөнгийн хөдөлгөөний хүснэгтээр харуулбал:

Дүрслэл 10



Дүрслэлээс харахад үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 91,739.5 мянган төгрөгөөр буюу 18.1 хувиар буурсан байна. Энэ нь “Сум дундын Ойн анги” ОНӨААТҮГ-т хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын хувьд:

2018 онд 43,479.5 мянган төгрөгийн бараа материалын эхний үлдэгдэлтэй байсан ба 71,472.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 13,148.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 101,803.3 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

2019 онд 101,803.3 мянган төгрөгийн бараа материалын эхний үлдэгдэлтэй байсан ба нийт 38,511.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, БОАЖЯ-аас 774.4 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй орлогоор, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрээр акталсан хөрөнгөөс 878.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч 10,185.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, БОАЖГ-ын даргын 2019.06.28-ны өдрийн А/14 тушаалаар 9,041.7 мянган төгрөгийн бараа материалыг акталж 122,740.5 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

2018-2019 онд БОАЖГ нь бараа материал болон үндсэн хөрөнгийн өөрчлөлтийг хууль журмын дагуу үнэн зөв бүртгэж, данс бүртгэлд тусгасан байна.

2.2.3 Өмч, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын 2018 оны А/04, 2019 оны А/03 дугаар тушаалаар өмч хамгаалах байнгын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан ба өмч хамгаалах зөвлөлийн ажиллах журмыг тушаалын хавсралтаар баталсан байна.

Өмч хамгаалах байнгын зөвлөл нь тайлант жил бүр ажлын төлөвлөгөө боловсруулж, тайлагнаж ажилласан байна. Мөн байгууллагын даргын тушаалаар 2018-2019 онд 4 удаа хөрөнгийн тооллогыг хийж, ажилчдын эд хөрөнгийн картыг шинэчилж, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг байгуулж, ажилласан байна.

Орон нутгийн өмчийн газартай байгуулсан орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээг 2018 онд 99 хувиар дүгнүүлж зөрчил дутагдал гараагүй учраас зөвлөмж өгөгдөөгүй байна. 2019 онд гэрээ дүгнэгдээгүй байна.

Аудитын явцад хөрөнгийн тооллого хийж тулган баталгаажуулахад хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт сайн, холбогдох техникийн ашиглалтыг бүрэн хөтөлсөн байна.

Дотоод хяналт үр дүнтэй эсэх

Бүлэг 3

Байгууллага дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1 Дотоод хяналт үр дүнтэй хэрэгжээгүй байна.

3.1.1 Байгууллагын удирдлага хууль тогтоомжоор хүлээсэн хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Тус байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотой ажлууд тусгагдсан боловч холбогдох хяналт шалгалтыг зохион байгуулаагүй байна.

Мөн байгууллагын удирдлага орон тоо дутуу ажилласан шалтгаанаар дотоод хяналт хариуцсан албан тушаалтныг томилоогүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311-р тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг тус тус зөрчсөн байна.

Иймд дээрх журмын хэрэгжилтийг хангаж, дотоод хяналтын нэгж, ажилтны ажил үүргийг тодорхой болгох, удирдлагын зүгээс хяналт шалгалт мониторинг хариуцсан мэргэжилтний орон тоонд холбогдох хууль журамд заасан шаардлага хангахуйц хүнийг томилж ажиллуулах, байгууллагын үйл ажиллагааны бүх чиглэлийг хамарсан дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөний дагуу ажил үүргээ чанартай гүйцэтгэх, дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахад анхаарах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.1.2 Бусад байгууллагаас тус газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.1.3 Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу Шилэн дансны цахим нэгдсэн хуудсанд 2018, 2019 онд тус тус 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Аудитаар нийт 7 зөрчил илэрснээс зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага, 6 зөвлөмж хүргүүлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1

- Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, орон нутгийн онцлог хууль эрх зүйн орчноос шалтгаалж тухайн ашигласан нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулах хөрөнгийг зориулалтын дагуу хуваарилах нөхцөл бүрдээгүй байна.
- Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөв санхүү, хүний нөөц дутагдалтай байгаагаас үр дүнтэй хэрэгжих нөхцөл нь бүрдээгүй байна.
- Байгууллагын дүрэм, засаг даргаар батлагдсан ажил үүргийн хуваарийг шинээр хэрэгжиж буй төрийн албаны тухай хууль, журам заавартай нийцүүлэн батлуулах шаардлагатай байна.
- Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдаагүй байна.

Бүлэг-2

- Үйл ажиллагааны зардлыг бодитой төлөвлөж арвилан хэмнэлттэй үр ашигтай зарцуулсан байна.
- Байгаль орчны үнэлгээ, усны асуудал хариуцсан мэргэжилтэн нь усны дүгнэлт гаргуулсан ААНБ-ын нэгдсэн бүртгэл хөтлөөгүй байна.
- Үйл ажиллагааны зардлыг хууль журмын дагуу үр ашигтай хэмнэлттэй зарцуулсан байна.
- Хөрөнгө бараа материалын худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна.
- Хөрөнгийг хууль журмын дагуу үнэн зөв бүртгэсэн байна.
- Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт үр нөлөөтэй байна.

Бүлэг-3

- Байгууллагын удирдлага хууль тогтоомжоор хүлээсэн хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- Бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.
- Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Үүнд:

Сүмдын Засаг дарга нарт:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрөөс тухайн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг хуульд заасны дагуу тооцож, сумын ИТХ-аар батлуулах, батлагдсан төсвийн хүрээнд аймгийн хэмжээнд байгаль орчны талаар баримталж буй дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэн ажлаа төлөвлөн ажиллах
2. Төрийн байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулах, байгаль орчин, аялал жуулчлалын талаар аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцүүлэн ажлаа төлөвлөж, хэрэгжүүлэх

Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргад:

1. Аймгийн Засаг даргын 2015 оны А/29 дүгээр захирамжаар батлагдсан байгууллагын дүрэм, ажил үүргийн хуваарь, бүтцийн схемийг шинээр хэрэгжиж буй төрийн албаны тухай хууль болон дагалдан гарсан дүрэм журамтай нийцүүлэх
2. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг мөрдөж ажиллах, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх
3. Ахлах нягтлан бодогчийн цалин хөлсийг хууль журамд нийцүүлэн үнэн зөв тогтоох
4. Дотоод хяналтын журмын хэрэгжилтийг хангаж, дотоод хяналтын нэгж, ажилтны ажил үүргийг тодорхой болгох, удирдлагын зүгээс хяналт шалгалт мониторинг хариуцсан мэргэжилтний орон тоонд холбогдох хууль журамд заасан шаардлага хангахуйц хүнийг томилж ажиллуулах, байгууллагын үйл ажиллагааны бүх чиглэлийг хамарсан дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөний дагуу ажил үүргээ чанартай гүйцэтгэх, дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахад анхаарах
5. Усны дүгнэлт гаргуулж байгаа байгууллага аж ахуйн нэгжүүдийн нэгдсэн бүртгэлийг хөтөлж, төлбөр төлөгдсөн байдалд хяналт тавьж ажиллах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас: 7054 3063,
И-мэйл: baigal@gov.mn

2020.06.29 № 206
Танай 2020.06.29 ны № 189 -Т

АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

Тус байгууллагын 2018, 2019 оны үйл
ажиллагааны үр дүнд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын
тайлангийн төсөлтэй танилцлаа.
Тайлангийн төсөлд өгөх тайлбар, санал үгүй
болно.

ДАРГА  Д.МӨНХ-ЭРДЭНЭ

Б. Дарханбаатар
Майганд саналгүй
тул тайланг
оффис баганаа-
нигүүлэх
Анх
4120300276 27/06

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

Шалгадагч байгууллагаас тайлангийн төсөлтэй холбоотой санал ирээгүй тул өөрчлөлт оруулаагүй болно.